ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ



2026 Aug

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

АГУУЛГА

I. СТАТИСТИКИЙН ТОЙМ 1

II. ГАДААД ЭДИЙН ЗАСАГ 2

2.1. Олон улсын эдийн засаг 2

2.2. АНУ-ын эдийн засаг 2

2.3. БНХАУ-ын эдийн засаг 3

2.4. Түүхий эдийн зах зээл 3

III. ДОТООД ЭДИЙН ЗАСАГ 6

3.1. Эдийн засгийн өсөлт 6

3.2. Инфляц 7

3.3. Улсын төсөв 8

3.4. Мөнгөний нийлүүлэлт 8

3.5. Нийт зээл 9

3.6. Гадаад худалдаа 10

3.7. Төлбөрийн тэнцэл, ханш 13

График, хүснэгтүүдийн жагсаалт

График 1 АНУ-ын инфляц 2
График 2 БНХАУ-ын инфляц 3
График 3 Түүхий эдийн үнийн төсөөлөл 4
График 4 Монгол улсын эдийн засгийн өсөлт 6
График 5 Инфляц ба Бодлогын хүү 7
График 6 Улсын төсөв 8
График 7 Мөнгөний нийлүүлэлт 9
График 8 Банкны салбарын зээл 10
График 9 Нийт экспорт, импорт 10
График 10 Экспортын голлох бүтээгдэхүүн 11
График 11 Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ, үнийн түвшин, 2026 7-р сар 11
График 12 Чулуун нүүрсний экспортын биет хэмжээ, үнийн түвшин, 2026 7-р сар 12
График 13 Импортын голлох бүтээгдэхүүн 12
График 14 Төлбөрийн тэнцэл 13

I. СТАТИСТИКИЙН ТОЙМ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026Q2	2026Q1	2025Q2	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	16,428	6,736	15,257	7.7%
Ажилгүйдлийн түвшин	%	5.5%	5.7%	4.5%	1%
Өрхийн сарын дундаж орлого	мянган төгрөг	3,497	3,490	3,305	5.8%
Өрхийн сарын дундаж зарлага	мянган төгрөг	3,273	3,391	3,094	5.8%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026M7	2026M6	2025M7	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам.доллар	12,206	10,393	7,752	57.4%
Зэс	сая ам.доллар	5,461	4,646	2,879	89.6%
Нүүрс	сая ам.доллар	4,637	3,942	3,020	56.4%
Нийт импорт	сая ам.доллар	7,158	6,117	6,482	10.4%
Хэрэглээ	сая ам.доллар	2,043	1,726	2,185	-6.5%
Хөрөнгө оруулалт	сая ам.доллар	2,861	2,435	2,621	9.2%
Аж үйлдвэрлэл	сая ам.доллар	683	582	511	33.7%
Шатахуун	сая ам.доллар	1,557	1,363	1,153	35.0%
Тэнцэл	сая ам.доллар	5,048	4,277	1,270	3.0x
Түүхий эдийн үнэ (Primary Commodity Prices, IMF, Монголбанк)					
Зэс	$/тонн	14,215	13,552	9,796	45.1%
Нүүрс (хилийн)	$/тонн	70.7	69.3	58	29.4%
Алт	$/трой унц	4644	4,590	3,371	38.1%
Газрын тос	$/баррел	92	84	68	37.2%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026M7	2026M6	2025M7	
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	тэрбум төгрөг	-2,206	-2,144	-1,299	69.8%
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого	тэрбум төгрөг	15,588	14,630	17,301	9.9.%
Төсвийн нийт зарлага	тэрбум төгрөг	19,507	16,773	16,888	15.5%
Мөнгөний бодлого					
М2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	53,124	53,145	42,424	25.2%
ХҮИ (С2023)	индекс	129.5	128.4	114.6	13%
Бодлогын хүү	%	12.5%	12%	12%	0.5%
Хүү ба ханш					
Нэрлэсэн ханш (хугацааны эцэст)	Төгрөг/$	3593	3,580	3,587	0.2%
Төгрөгийн хадгаламж (тухайн сард шинээр татсан)	%	11.44%	11.07%	11.40%	0.04%
Валютын хадгаламж (тухайн сард шинээр татсан)	%	4.13%	3.57%	4.49%	-0.36%
Төгрөгийн зээл (Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү)	%	17.41%	17.59%	17.10%	0.31%
Валютын зээл (Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү)	%	11.05%	11.71%	11.13%	-0.08%
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам.доллар	7,962	7,656	5,379	48.0%

II. ГАДААД ЭДИЙН ЗАСАГ

2.1. Олон улсын эдийн засаг

Олон улсын байгууллагуудын тайлангуудад дурдсанаар дэлхийн эдийн засгийн өсөлт геополитикийн хурцадмал байдал, эрчим хүчний зах зээлийн савлагаатай холбоотойгоор саарах төлөв ажиглагдлаа. Дэлхийн эдийн засгийн өсөлт 2026 онд 2.5-3.0 хувьд хүрч, сүүлийн жилүүдийн хамгийн сул үзүүлэлтүүдийн нэг болох төлөвтэй байна.

Ойрхи Дорнодын мөргөлдөөнтэй холбоотойгоор нефт, эрчим хүчний нийлүүлэлтэд эрсдэл үүсэж, газрын тосны үнэ өсөөд байна. Улмаар үйлдвэрлэлийн зардал нэмэгдэж, олон улсын хэмжээнд инфляцын дарамт үргэлжилж байна. Нөгөө талаас хөгжиж буй эдийн засагтай орнуудын гадаад өрийн хэмжээ өсөж, өндөр хүүтэй санхүүжилтийн дарамт эдийн засгийн идэвхжилийг хязгаарлах хүчин зүйл болж байна. Инфляцыг бууруулах зорилгоор төв банкнууд мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж байгаа ч гадаад орчны тодорхойгүй байдал үнийн өсөлтийг сааруулах үйл явцыг удаашруулжээ. Үүнээс гадна томоохон эдийн засгуудын худалдааны маргаан, тарифын зөрчил нь дэлхийн худалдааны урсгалд сөрөг нөлөө үзүүлж, нийлүүлэлтийн сүлжээний эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Цаашдын төлөвөөр 2027 онд дэлхийн эдийн засгийн өсөлт 2.7-3.4 хувьд хүрч бага зэрэг сэргэхэд хиймэл оюун ухаан болон дэвшилтэт технологийн хөрөнгө оруулалт гол нөлөө үзүүлэх хэдий ч үр өгөөж нь улс орон бүрд харилцан адилгүй, хүртээмж нь жигд бус байх төлөвтэй байна. Харин геополитикийн зөрчил хурцдах эсвэл санхүүгийн зах зээлийн хэлбэлзэл нэмэгдэх тохиолдолд дэлхийн эдийн засгийн өсөлтөд шинэ сорилтууд тулгарч болзошгүй.

2.2. АНУ-ын эдийн засаг



График 1 АНУ-ын инфляц

2026 оны 7 дугаар сард АНУ-д ажлын байр 23 мянгаар буурч, ажилгүйдлийн түвшин 4.1%, инфляц 3.4% түвшинд хүрсэн нь эдийн засгийн идэвхжил саарч байгааг илтгэж байна. Инфляц зорилтот түвшин болох 2%-аас өндөр байгаа тул 7 сарын ХНС-гийн хурлаар бодлогыг хүүг 3.5-3.75%-д хэвээр хадгалах шийдвэр гарсан. Хүүгийн уг бодлого нь ам.долларын өгөөжийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдын хөрөнгийг АНУ-руу төвлөрөх нөхцөлийг бий болгож байна. Улмаар ам.долларын эсрэг бусад улсын валютууд суларч, санхүүжилтийн нэмэлт дарамтыг үүсгэх эрсдэлтэй байна. Мөн АНУ нь

хамгийн том импортлогч улс болохын хувьд хэрэглээ саарч байгаа нь экспортлогч орнуудын үйлдвэрлэлийн өсөлтийг хязгаарлаж байна.

Харин гадаад худалдааны хувьд АНУ 80 гаруй улс орны импортын бараанд 10-12.5%-ийн тариф ногдуулах шийдвэрийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү тариф нь АНУ-ын нийт импортын барааны бараг бүх хэсгийг хамарч байгаа бөгөөд Хятад, Европын холбоо, Мексик, Канад, Энэтхэг зэрэг худалдааны гол түншүүд нь багтаж байна. Шинэ тарифын арга хэмжээ нь импортын барааны өртөг болон бизнесийн зардлыг нэмэгдүүлж, улмаар үнийн өсөлтөөр дамжин инфляцын дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй тулгарчээ. Төсвийн хувьд тарифын бодлогын өөрчлөлтийн нөлөөгөөр 2026 оны гаалийн орлого өмнөх төсөөллөөс 250 тэрбум ам.доллараар бага байхаар тооцоологдож байгаа бөгөөд ирэх 10 жилийн хугацаанд төсвийн алдагдлыг 900 тэрбум ам.доллараар нэмэгдүүлэх төлөвтэй байна.

2.3. БНХАУ-ын эдийн засаг

График 2 БНХАУ-ын инфляц



БНХАУ-ын эдийн засгийн хувьд 7-р сард идэвхжил саарсан байна. Тухайлбал, жижиглэн худалдааны борлуулалтын жилийн өсөлт 0.6% болж өмнөх сарын 1%-ийн өсөлтөөс буурсан бол аж үйлдвэрлэлийн өсөлт 4.5%-тай гарчээ.

Гадаад худалдааны хувьд экспортын өсөлт эрчимжиж байгаагийн нөлөөгөөр 112.5 тэрбум ам.долларын ашигтай байсан ч өмнөх сараас 12 тэрбум ам.доллараар буурсан байна. Экспортын өсөлтөд хиймэл оюун ухаан, хагас дамжуулагч, цахилгаан автомашин болон өндөр технологийн бүтээгдэхүүний экспорт хүчтэй нөлөөлжээ.

Инфляцын хувьд нам дор түвшинд буюу 0.9%-тай тэнцэж, Хятадын Ардын Банк бодлогын хүүгээ 3.0%-д хадгалах шийдвэр гаргажээ. Төсвийн бодлогын хувьд дотоод эрэлтийг дэмжих зорилгоор зарлагыг өндөрт хадгалснаар төсвийн алдагдал ойролцоогоор ДНБ-ий 6.5%-тай тэнцэх хэмжээнд хүрээд байгаа юм.

БНХАУ эдийн засгийн идэвхжлийг дэмжих чиглэлээр олон талт бодлогын арга хэмжээ хэрэгжүүлж байгаа хэдий ч үл хөдлөх хөрөнгийн салбарын үргэлжилсэн хүндрэл, орон нутгийн засаг захиргааны өрийн дарамт нь эдийн засгийн өсөлтөд гол эрсдэл болсон хэвээр байна.

2.4. Түүхий эдийн зах зээл

Дэлхийн эдийн засгийн орчин дахь геополитикийн эрсдэл, худалдааны бодлогын тодорхойгүй байдлаас шалтгаалж санхүүгийн болон түүхий эдийн зах зээл хэлбэлзэл өндөртэй хэвээр байна. Ялангуяа Ойрх Дорнод дахь хурцадмал байдал нь эрчим

хүчний нийлүүлэлт дэх эрсдэлийг нэмэгдүүлж, газрын тос болон байгалийн хийн үнийг өндөр түвшинд хадгалагдахад нөлөөлж байна. Үүнтэй зэрэгцэн тээвэрлэлтийн зардал өссөнөөр бусад түүхий эдийн зах зээл дэх үнийн дарамт үргэлжилсээр байна.

График 3 Түүхий эдийн үнийн төсөөлөл



* Таамаглал
Спот үнэ 2026 оны 8-р сарын 25-ний байдлаар
Эх сурвалж: Bloomberg Terminal, World Bank

Алт: Алтны үнэ оны эхнээс 4.6%-иар өсөж, 4,645 ам.доллар/унц орчимд хүрээд байна. Оны эхээр төв банкуудын худалдан авалт болон аюулгүй хөрөнгө оруулалтын эрэлт нэмэгдсэнээр үнэ 1-р сард түүхэн дээд түвшин болох 5,417 ам.долларт хүрсэн. Харин оны дунд үед АНУ-ын мөнгөний бодлого чангарч болзошгүй гэсэн хүлээлт нэмэгдэж, ам.долларын ханш чангарснаар алтны үнэ 7-р сард 3,977 ам.доллар хүртэл буурсан байна. Улмаар 8-р сард АНУ-ын хүүгийн өсөлтийн хүлээлт саарч, ам.долларын ханш суларсан, мөн Хятадын алтны импорт нэмэгдсэнээр алтны эрэлт сэргэж, үнэ дахин өсөж 4,500 ам.доллар орчимд тогтворжоод байна. Цаашид төв банкуудын худалдан авалт, АНУ-ын мөнгөний бодлого болон геополитикийн нөхцөл байдал алтны үнийн төлөвийг тодорхойлох гол хүчин зүйлс хэвээр байна.

Зэс: Зэсийн үнэ 2026 онд өндөр түвшинд хадгалагдаж, оны эхнээс 12.6%-ийн өсөлттэй байна. Үнийн өсөлтөд АНУ-ын импортын тарифтай холбоотой эрсдэлээс шалтгаалан худалдан авалт нэмэгдсэн, Перу болон Чилийн уурхайн нийлүүлэлтийн саатал үүссэн, мөн хиймэл оюун ухаан, дата төв болон эрчим хүчний дэд бүтцийн хөрөнгө оруулалт эрчимжсэн зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлжээ. Түүнчлэн нийлүүлэлтийн хомсдол үргэлжилж, дэлхийн зах зээлд зэсийн нөөц буурсан нь үнийг дэмжсэн хэвээр байна. Хэдийгээр өндөр үнийн нөлөөгөөр Хятадын эрэлт тодорхой хэмжээнд саарч байгаа ч нийлүүлэлтийн хүндрэл болон эрчим хүчний шилжилттэй холбоотой бүтцийн эрэлт зэсийн үнийг өндөр түвшинд хадгалах төлөвтэй байна.

Газрын тос: Газрын тосны зах зээлд геополитикийн эрсдэл өндөр хэвээр хадгалагдлаа. Катарын шингэрүүлсэн байгалийн хий тээвэрлэгч хөлөг онгоц болон Саудын Арабын газрын тосны танкеруудад халдсан явдал нь тээвэрлэлтийн аюулгүй байдлын эрсдэл нэмэгдсэн. Үүнээс гадна АНУ-аас Ормузын хоолойгоор дамжин өнгөрөх тээвэрт нэмэлт татвар ногдуулах асуудлыг хэлэлцсэн нь зах зээлд тодорхойгүй байдал бий болгож үнийг өсгөхөд нөлөөлжээ. OPEC+ орнууд олборлолтоо тодорхой хэмжээгээр нэмэгдүүлсэн ч нийлүүлэлтийн эрсдэлийг бүрэн нөхөж чадахгүй хэвээр байна. Харин өндөр үнэ удаан хугацаанд хадгалагдсанаар дэлхийн эрэлт саарч эхэлсэн бөгөөд үүний нөлөөгөөр Брент газрын тосны үнэ 8-р сарын сүүлчээр баррель тутамд 86-90 ам.долларын орчимд тогтворжиж байна.

Нүүрс: Нүүрсний үнэ 2026 онд харьцангуй өндөр түвшинд хадгалагдаж байна. Үүнд Ирантай холбоотой геополитикийн хурцадмал байдал болон шингэрүүлсэн байгалийн хийн нийлүүлэлтийн хүндрэлээс шалтгаалан нүүрсний хэрэглээ нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Түүнчлэн Индонез болон Хятадад үүссэн нийлүүлэлтийн хязгаарлалт, Хятадын зуны халуун цаг агаараас үүдэлтэй цахилгаан эрчим хүчний хэрэглээний өсөлт нь эрэлтийг дэмжсэн байна. Европын зах зээлд байгалийн хийн үнэ өсөж, нүүрсээр ажилладаг цахилгаан станцуудын ашигт ажиллагаа сайжирсан нь нүүрсний үнийг дэмжих нэмэлт хүчин зүйл болсон. Иймээс нүүрсний үнэ оны турш харьцангуй өндөр түвшинд хадгалагдаж, цаашдын төлөв нь эрчим хүчний зах зээлийн нөхцөл байдал болон нийлүүлэлтийн өөрчлөлтөөс хамааран тодорхойлогдохоор байна.

III. ДОТООД ЭДИЙН ЗАСАГ

3.1. Эдийн засгийн өсөлт

2026 оны эхний хагас жилийн байдлаар ДНБ (үйлдвэрлэлийн аргаар, 2015 оны үнээр) 16.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 7.7% өссөн байна.

График 4 Монгол улсын эдийн засгийн өсөлт



Эх сурвалж:УСХ

*Ийнхүү өсөхөд уул уурхай, олборлолтын салбар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.5%-аар [1], хөдөө аж ахуйн салбар 11.3%-аар өссөн нь голлон нөлөөлжээ. Салбар*уудын *оролцооны хувиар авч үзэхэд нийт эдийн засгийн өсөлтийн 3.9 нэгж хувийг уул уурхай, олборлолтын салбар, 1.8 нэгж хувийг тээвэр, үйлчилгээний салбар бүрдүүлсэн бол удаалж 1.4 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбар дангаар бүрдүүлсэн байна. Зэс болон нүүрсний үйлдвэрлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн нь уул уурхайн салбарын өсөлтийг голлон тайлбарласан хэвээр бөгөөд үүнтэй уялдан тээврийн салбар* идэвхжиж *байна.*

Хүснэгт 1 Эдийн засгийн өсөлтөд салбаруудын оролцоо, 2026 оны эхний хагасын байдлаар

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, САЛБАРААР	Оролцоо		Жилийн өсөлт	
Хугацаа	Q1	Q2	Q1	Q2
ДНБ	7.9%	7.7%	7.9%	7.7%
ХАА	0.4%	1.4%	11.4%	11.3%
Уул уурхай, олборлолт	**5%**	**3.9%**	**33.6%**	**31.5%**
Үйлдвэрлэл, барилга	0.1%	0.5%	4.1%	4.1%
Боловсруулах	-0.4%	0.1%	-6.6%	1.2%
Барилга	0.1%	0.2%	9.5%	7.9%
Эрчим хүч	0.4%	0.2%	8%	7.4%
Үйлчилгээ	2.2%	1.8%	3.8%	3.8%
Бөөний, жижиглэн худалдаа	-0.1%	0.0%	-0.8%	-0.2%
Тээвэр	1.1%	0.8%	23.8%	21.5%
Мэдээлэл, холбоо	0.3%	0.3%	6.6%	6.1%
Үйлчилгээний бусад	0.9%	0.8%	2.7%	2.6%
Бүтээгдэхүүний цэвэр татвар	0.2%	0.1%	1.1%	0.3%

Эх сурвалж: УСХ, Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ

[1] *Голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр авч үзэхэд өмнөх оны мөн үеэс нүүрсний олборлолт 52.4%-аар, харин зэсийн баяжмалын үйлдвэрлэл 20.0%-аар өссөн байна.*

3.2. Инфляц

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) 2026 оны 7 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.0%, өмнөх сараас 0.9%-аар тус тус өсөж, инфляцын дарамт үргэлжлэн нэмэгдсээр байна.

Жилийн инфляцыг бүрэлдэхүүнээр авч үзвэл өсөлтийн голлох дарамт хүнсний бүлгээс үүссэн хэвээр байна. Тухайлбал, хүнсний бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 25.5%-иар өсөж, нийт инфляцын 7.0 нэгж хувь буюу 53.7%-ийг бүрдүүлсэн нь хамгийн өндөр нөлөө үзүүлжээ. Үүнээс мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлт голлон нөлөөлсөн бөгөөд 2026 оны 7 дугаар сард мах, махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 52.4%-иар өссөн байна. Тодруулбал, үхрийн махны үнэ 55.9%-иар, хонь, ямааны махны үнэ 63.6%-иар тус тус нэмэгджээ. Энэхүү махны үнийн өсөлтөд голлон махны экспортын өсөлт, тээврийн зардал болон малчдын амьжиргааны түвшний нөхцөл байдал зэрэг нь нөлөөлж байна.

График 5 Инфляц ба Бодлогын хүү



Эх сурвалж: Монголбанк, ҮСХ

Дотоодын хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийн зэрэгцээ импортын барааны үнийн өсөлт инфляцад мэдэгдэхүйц нөлөө үзүүлсээр байна. Нийт инфляцын 3.5 нэгж хувь буюу 26.5% нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан бөгөөд үүнээс бензин, түлшнээс бусад импортын барааны үнэ 2.3 нэгж хувийг бүрдүүлжээ. Түүнчлэн тээврийн бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 17.0%-иар өсөж, инфляцад 1.5 нэгж хувийн нөлөө үзүүлсэн байна. Сарын өөрчлөлтөөр авч үзвэл, 2026 оны 7 дугаар сард хэрэглээний үнэ өмнөх сараас 0.9%-иар өсөхөд хүнсний бүлгийн үнэ 0.7%-иар, тээврийн бүлгийн үнэ 2.6%-иар өссөн нь голлон нөлөөлжээ.

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2026 оны 8-р сарын ээлжит бус хурлаараа инфляцын хүлээлтийг тогтворжуулах, нийлүүлэлтийн шалтгаант үнийн өсөлтийн хоёрдогч нөлөөг хязгаарлах зорилгоор бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж 12.5%-д, төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж 14.5%-д хүргэх шийдвэр гаргалаа. Иймд ойрын хугацаанд мөнгөний бодлогын төлөв чангарсан хэвээр үргэлжлэх хүлээлттэй байна.

3.3. Улсын төсөв

2026 оны эхний 7 сард улсын нэгдсэн төсвийн орлого өссөн хэдий ч зарлагын өсөлт өндөр хэвээр үргэлжилснээр төсвийн алдагдал нэмэгдлээ. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 17.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.0%-иар өссөн бол нийт зарлагын хэмжээ 19.5 их наяд төгрөг болж 15.5%-иар өссөн байна. Үүний дүнд төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2.2 их наяд төгрөгийн алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийн 1.3 их наяд төгрөгийн алдагдлаас 69.8%-иар буюу 907.1 тэрбум төгрөгөөр нэмэгдлээ.

Төсвийн зардлын бүтцийн гол бүрэлдэхүүнээр авч үзвэл, 2026 оны эхний 7 сард урсгал шилжүүлэг нийт зардлын 38.5%-ийг бүрдүүлж, нийт дүнгээр өмнөх оны мөн үеэс 8.0%-иар өссөн байна. Мөн нийт зардлын 35.2%-ийг эзэлж буй бараа, үйлчилгээний зардал 18.3%-иар, нийт зардлын 18.4%-ийг бүрдүүлж буй хөрөнгийн зардал 31.8%-иар өссөн нь нийт зарлагын өсөлтийн гол хөдөлгөгч хүчин зүйл болж, төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт нэмэгдсэнийг харуулж байна.

График 6 Улсын төсөв



Эх сурвалж: УСХ

Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын бүтцийг харвал татварын нийт орлогын 31.2%-ийг орлогын албан татвар, 23.3%-ийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 22.0%-ийг нийгмийн даатгалын орлого, 7.0%-ийг гадаад үйл ажиллагааны орлого, 3.3%-ийг онцгой албан татвар, үлдсэн 13.2%-ийг бусад төрлийн татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна. Тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 11.0%-иар өсөхөд нийгмийн даатгалын орлого 15.8%-иар, нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 12.1%-иар, орлогын албан татварын орлого 9.8%-иар, бусад татварын орлого 13.8%-иар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Харин суудлын автомашины импорт буурсантай холбоотойгоор онцгой албан татварын орлого 16.2%-иар буурсан нь орлогын өсөлтийг сааруулах нөлөө үзүүлсэн байна.

3.4. Мөнгөний нийлүүлэлт

2026 оны 7 дугаар сарын эцэст мөнгөний нийлүүлэлт (М2) өмнөх оны мөн үеэс 25.2%-иар өсөж, 53.1 их наяд төгрөгт хүрлээ. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг эх

үүсвэр (пассив) талаас авч үзвэл, төгрөгийн хадгаламж 28.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 5.8 их наяд төгрөгөөр буюу 25.1%-иар өссөн байна. Мөн төгрөгийн харилцах 11.5 их наяд төгрөгт хүрч 2.3 их наяд төгрөгөөр буюу 24.6%-иар, валютын харилцах 6.7 их наяд төгрөгт хүрч 2.9 их наяд төгрөгөөр буюу 76.9%-иар тус тус өссөн нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн гол хүчин зүйл болжээ. Харин валютын хадгаламж 5.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 376.1 тэрбум төгрөгөөр буюу 6.9%-иар буурсан байна. Төгрөгийн хадгаламжийн 82.0%-ийг иргэдийн хадгаламж, 18.0%-ийг аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламж бүрдүүлж байна.

График 7 Мөнгөний нийлүүлэлт



Эх сурвалж: УСХ

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд байршуулалт (актив) талаас гадаад цэвэр активын өсөлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, гадаад цэвэр актив 2026 оны 7 дугаар сарын эцэст 11.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.7 их наяд төгрөгөөр буюу 2.3 дахин өссөн байна. Энэ нь экспортын орлого болон төлбөрийн тэнцэлийн ашиг нэмэгдсэнтэй холбоотой. Харин зээлийн өсөлттэй голлон холбоотойгоор дотоод цэвэр актив 41.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.0 их наяд төгрөгөөр буюу 10.8%-иар өссөн нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг дэмжжээ.

3.5. Нийт зээл

Нийт зээлийн үлдэгдэл 2026 оны 7-р сард 47.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.5 их наяд төгрөгөөр буюу 13.0%-аар өссөн бол өмнөх сараас 1.1 их наяд төгрөгөөр буюу 2.2%-иар буурчээ. Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 2.9%-иар, өмнөх оны мөн үеэс 17.0%-иар өсөж 2.5 их наяд төгрөгт хүрэв. Харин чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 5.2% байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар өссөн үзүүлэлт бөгөөд анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл 1.2 их наяд төгрөг болж нийт зээлийн 2.6%-ийг бүрдүүлж байна.

2026 оны 7-р сарын байдлаар нийт зээлийн жилийн өсөлт 13.0%-д буйгаас хэрэглээний болон хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт 4.5%-д хүрж эрчимтэйгээр буурсан бол бизнесийн зээлийн өсөлт 18.5%-д хүрч нийт зээлийн өсөлтийг голлон дэмжжээ. Ипотекийн зээлийн өсөлт 7-р сард 18.6%-д хүрсэн ба бусад зээлийн өсөлттүүдтэй харьцуулахад харьцангуй тогтвортой түвшинд хадгалагдаж байна. Өндөр

хүүгийн орчин болон хатуу мөнгөний бодлогын нөлөөгөөр ийнхүү зээлийн өсөлт 2026 оны туршид үргэлжлэн саарч байна.

График 8 Банкны салбарын зээл



3.6. Гадаад худалдаа

2026 оны эхний долоон сарын урьдчилсан гүйцэтгэлээр нийт экспорт 12,205 сая ам.доллар, нийт импорт 7,158 сая ам.долларт хүрч тус бүр харгалзан өмнөх оны мөн үеэс 57.5 хувь ба 10.4 хувиар өсжээ. Улмаар худалдааны тэнцлийн ашиг 5,047 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.0 дахин өслөө.

График 9 Нийт экспорт, импорт



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Нийт экспортын 57.5 хувийн өсөлтийн 33.2 нэгж хувийг зэсийн баяжмалын орлогын өсөлт, харин 22.4 нэгж хувийг нүүрсний экспортын орлого тайлбарлаж байна. Тухайлбал өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэсийн баяжмалын орлого 89.7%-аар, нүүрсний экспортын орлого 59.0%-аар, мөн алтны экспортын орлого 9.7%-аар өсөөд байна.

График 10 Экспортын голлох бүтээгдэхүүн



Эх сурвалж: Монголбанк

Зэсийн баяжмалын биет хэмжээ эхний зургаан сард 1,529.1 мянган тоннд хүрсэн ба сарын дундаж хилийн үнэ тонн тутамд 3,571 ам.доллар болж, өмнөх сараас өссөн төдийгүй өмнөх оны мөн үеэс 23.1 хувиар өсжээ. Цаашид цахилгаан автомашин, эрчим хүчний шилжилт, хиймэл оюун ухаанаас шалтгаалсан металлын эрэлт нэмэгдэх төлөвтэй байгаагаас зэсийн үнэ дунд хугацаанд өндөр түвшинд хадгалагдах хүлээлт давамгайлж байна.

График 11 Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ, үнийн түвшин, 2026 7-р сар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Нүүрсний зах зээлийн хувьд 2026 оны 7-р сард БНХАУ-ын Шаньси муж дахь уурхайн ослын дараах аюулгүй ажиллагааны хяналт шалгалт үргэлжилж, уурхайн үйлдвэрлэл хэвийн түвшинд хүрээгүй хэвээр байна. Мөн гангийн салбарт улирлын чанартайгаар эрэлт суларч, коксжуулах үйлдвэрүүд болон ган үйлдвэрлэгчдийн худалдан авах идэвх буурснаар нүүрсний зах зээлийн эрэлт агшиж, коксжих нүүрсний үнэ тогтвортой төлөвтэй байлаа.

Дотоодын нийлүүлэлтийн хязгаарлалтын улмаас 2026 оны эхний хагаст БНХАУ нийт 66.8 сая тонн коксжих нүүрс импортолсон нь өмнөх оны мөн үеэс 26.6 хувиар өссөн үзүүлэлт болсон байна. Үүнээс 40.6 сая тонн буюу нийт импортын 60.7 орчим хувийг Монгол Улс нийлүүлсэн бөгөөд Монголоос импортолсон хэмжээ өмнөх оны мөн үеэс 63.9 хувиар өсжээ. Цаашид дотоодын уурхайн нийлүүлэлт аажмаар сэргэх төлөвтэй ба гангийн салбарын эрэлт сул хэвээр үргэлжлэхээр байгаа тул 2026 оны 8-р сард коксжих нүүрсний үнэ бага зэрэг буурах төлөвтэй байна (Sxcoal, 2026).

График 12 Чулуун нүүрсний экспортын биет хэмжээ, үнийн түвшин, 2026 7-р сар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Харин импортын зардлын задаргааны хувьд нефтийн бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 35.0%-аар өссөн бол суудлын болон ачааны автомашины импорт өмнөх оны мөн үеэс буурсан хэвээр байна. Нефтийн бүтээгдэхүүний өсөлтийг бүрэлдэхүүн хэсгээр авч үзэхэд нийт өсөлтийн 29.2 нэгж хувийг зуны дизель түлш, харин 4.7 нэгж хувийг АИ 92 бензиний худалдан авалт голлон бүрдүүлжээ.

График 13 Импортын голлох бүтээгдэхүүн



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

3.7. Төлбөрийн тэнцэл, ханш

2026 оны эхний хагасын байдлаар гадаад худалдааны ашиг нэмэгдсэнтэй холбоотойгоор урсгал данс 207.2 сая ам.долларын ашигтай гарчээ. Үүнд бараа, үйлчилгээний дансны экспортын орлого 64% нэмэгдэж 11.2 тэрбум ам.долларт хүрсэн нь голлон нөлөөлөв. Харин гадаад зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгал нэмэгдсэн ч улсын болон хувийн секторын олон улсын зах зээлд гаргасан бондуудын нөлөө нь хөрөнгийн цэвэр орох урсгалыг дэмжиж, тайлант хугацаанд санхүүгийн данс 209.3 сая ам.долларын ашигтай гарлаа.

Ийнхүү төлбөрийн тэнцэл 2026 оны 6-р сарын байдлаар 566 сая ам.долларын ашигтай гарч, гадаад валютын албан нөөц (ГВАН) өндөр түвшинд хадгалагдаж байна. ГВАН 7-р сарын шинэчлэгдсэн статистикаар 7.97 тэрбум ам.доллар хүрч, төгрөгийн ханш тогтвортой хадгалагдах суурь нөхцөлийг бий болгож байна. Тухайлбал төгрөгийн албан ханш 7-р сарын эцэст 3,593 төгрөг/ам.доллартай тэнцэж, оны эхнээс 1.0 хувиар суларчээ.

График 14 Төлбөрийн тэнцэл



Эх сурвалж: Монголбанк

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

7575-1111 /1277/
eru@golomtbank.com
www.dua.golomtbank.com

Голомт банкны төв байр,
Сүхбаатарын талбай 5, Ш/х-22,
Улаанбаатар 15160, Монгол Улс
SWIFT: GLMT MNUB

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны хэлтэс нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.